



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/392

Мандалговь

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын дөрөв дүгээр хавсралтын 6 дахь хэсэгт тусгагдсан “Дэрэн сумын хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар”-ын ажлын 18,071,490 (арван найман сая далан нэгэн мянга дөрвөн зуун ер) төгрөг, 7 дахь хэсэгт тусгагдсан “Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний засварын ажлын 5,349,000 (таван сая гурван зуун дөчин есөн мянга) төгрөгийн төсөл арга хэмжээг Дэрэн суманд эрх шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлыг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжилтийг олгож, явцын мэдээллийг сар бүрийн 2-ны өдрийн дотор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст тайлагнахыг Дэрэн сумын Засаг дарга (Л.Амартүвшин)-д даалгасугай

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Энхтайван)-т нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

4823100785